






## ГеоГebra сургалтын системд бүртгүүлэх

### Бүртгүүлэх

Нэвтрэх эрхээ ашиглан бүртгүүлнэ үү ...

 Google  Office 365  Microsoft  Facebook  Twitter

ГеоГebra нэвтрэх эрхээ ашиглан бүртгүүлэх

Имэйл

Хэрэглэгчийн нэр

Нууц үг

Нууц үгээ баталгаажуулах

Зөвшөөрөл  Дараах сонголтуудын аль нэгийг сонгоно уу

Би 14-өөс дээш настай гэдгээ, [Үйлчилгээний нөхцөл](#) болон [Нууцлалын бодлого](#)-г уншиж, агуулгатай нь санал нийлж байгаагаа хүлээн зөвшөөрч байна.

Хүүхдийнхээ өмнөөс би [Үйлчилгээний нөхцөл](#) болон [Нууцлалын бодлого](#)-г уншсан, агуулгатай нь санал нийлж байгаагаа хүлээн зөвшөөрч байна.

Зураг 1. Нэвтрэх эрх үүсгэх хэсэг

**Мэйл** – өөрийн ямар нэгэн мэйл (gmail хаяг илүү нийцтэй) хаягаараа бүртгэл үүсгэнэ.



ГеоГebra сургалтын систем дээр болж буй аливаа үйл ажиллагааны тухай мэдээ энэхүү бүртгүүлсэн мэйлээр тань байнга мэдэгдэл болж ирэх тул шинэ мэдээ, зарыг цаг алдалгүй авах нөхцөл бүрдэнэ.

**Хэрэглэгчийн нэр** – Өөрийн нэрийг латин үсгээр галиглаж бичнэ. Хэрэв таны өгч буй хэрэглэгчийн нэр өмнө нь үүссэн гэсэн мэдээ танд өгвөл тухайн нэрнийхээ ард тоо эсвэл овгийн эхний 3 үсгээ бичиж ялгаж өгөөрэй. Фэйсбүүк эрхээ ашиглан нэвтрэхгүй байхыг зөвлөж байна.



Хэрэглэгчийн нэрийг өөрийн нэрнээс өөрөөр, жишээлбэл богино дууддаг нэр, хоч, товчлол хэрэглэх гэх мэт бусдад таныг гэж танигдахгүй нэр өгөхгүй байх.

**Нууц үг** – Өөрөө мартажгүй үсэг тоо оролцуулан нууц үг оруулна.




Нууц үгээ мартаггүй, найдвартай бичиж тэмдэглэж, хадгалахыг сануулж байна. Нууц үгээ мартсанаас шалтгаалан гарах аливаа маргаан, будлиан гаргахгүй байхыг зөвлөж байна. Иймд хэрэглэгчийн нэр, нууц үгээ сайтар тогтоож авна уу.

Нэвтрэх эрх авах

дар.

## Тогтмол нэвтрэх

Анх бүртгүүлж нэвтэрснээс хойш ГеоГебра сургалтын систем рүү орохдоо веб хөтчийн хаяганд <https://www.geogebra.org/> гэж бичнэ.




Зураг 2. Геогебра сайт

**Нэвтрэх** товчлуурыг дарж дээр шинээр үүсгэсэн Хэрэглэгчийн нэр эсвэл бүртгэлтэй мэйл хаягаа бүтнээр бичин, нууц үгээ оруулж нэвтрээрэй.

Таны хувийн төхөөрөмж биш бол та ГеоГебра сайт дээрх өөрийн нэвтрэх эрхээсээ заавал гарч байгаарай. Ингэснээр ГеоГебра дээр хийгдсэн таны аливаа, материал, даалгавар, хэлэлцүүлэг, мессеж гэх мэт гүйцэтгэсэн үйлдлүүдийн мэдээллийн нүүцлалыг хамгаална.

ГеоГебра сургалтын системээс гарахдаа дэлгэцийн баруун дээд буланд байрлах өөрийн профайл зураг дээр дарж босоо гурван цэг, тэгээд **Гарах** товчлуурыг сонгоно.



Зураг 3. Геогедра дээрх нэвтрэх эрхээсээ гарах

## Зургаа оруулах

Хэрэглэгч цээж зургаа оруулахдаа профайлын том зураг дээр маузыг аваачихад гарч ирэх аппаратны зураг дээр даран өөрийн компьютер (гар утас, зөөврийн төхөөрөмж) дээр хадгалсан зургийнхаа замыг зааж өгнө. Ойрын зайнаас авсан, царай тод харагдахуйц цээж зургаа өмнө нь бэлдэж хадгалаарай.

